

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2026 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр, Лхагва гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-24

1. Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах протоколын төсөл /Засгийн газар 2026.03.17-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/	4-24
---	------

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
4 дүгээр сарын 01-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 55.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 31 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Эмнэлгийн чөлөөтэй: Л.Энхнасан;

Тасалсан: О.Амгаланбаатар, Э.Бат-Амгалан, Б.Жаргалан, Ц.Мөнхбат, З.Мэндсайхан, Л.Оюун-Эрдэнэ, Х.Тэмүүжин, Г.Хосбаяр, Р.Эрдэнэбүрэн.

Нэг.Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах протоколын төсөл /Засгийн газар 2026.03.17-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, мөн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, Гэрээ, эрх зүй, гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Т.Ганбаатар, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирал Ж.Соёлмаа, мөн яамны Хөрш орнуудын газрын захирал Т.Жанабазар, мөн газрын дэд захирал Д.Өнөбилэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, зөвлөх С.Дунжидмаа, референт Б.Гандиймаа, А.Наранцэцэг нар байлцав.

Төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл, Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нар тус тус танилцуулав.

Танилцуулга болон Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Х.Жангабыл, Д.Ганбат, Л.Гантөмөр, Б.Тулга, Г.Дамдинням нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирал Ж.Соёлмаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөр, Ч.Анар, Ж.Энхбаяр, Д.Ганбат, Г.Очирбат, Г.Тэмүүлэн нар үг хэлэв.

Г.Тэмүүлэн: Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах протоколыг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөрийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 68.4 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

Уг асуудлыг 15 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 13 минут үргэлжилж, 29 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 65.5 хувийн ирцтэйгээр 15 цаг 44 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

2026 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр, Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
14 цаг 31 минут.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн байна. Та бүхэнд ирцийг танилцуулаадахъя.

Чинбаатарын Анар гишүүн, Энхбатын Болормаа гишүүн, Дуламын Бум-Очир гишүүн, Дашдондогийн Ганбат гишүүн, Лувсаннъямын Гантөмөр гишүүн, Хажикберийн Жангабыл гишүүн, Сүрэнжавын Лүндэг гишүүн, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн, Нямтайширын Номтойбаяр гишүүн, Ганбатын Очирбат гишүүн, Буяагийн Тулга гишүүн, Дамдины Цогтбаатар гишүүн, Өлзийхүүгийн Шижир гишүүн, Баттөмөрийн Энхбаяр гишүүн, Жадамбаагийн Энхбаяр гишүүн, Дашцэрэнгийн Энхтүвшин нарын гишүүд хүрэлцэн ирснээр 2026 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. 4 асуудал байгаа.

1 дүгээрт Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон өөрчлөлт оруулах протоколын төсөл байгаа. /Засгийн газар 3 сарын 17-ны өдөр хүргүүлсэн, зөвшилцөх/ асуудал байгаа.

2 дугаарт Төрийн албаны нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд

3 дугаарт Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөл

4 дүгээрт Гадаад харилцааны яамны 2025 оны үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээлэл сонсох гэсэн ийм асуудлууд байгаа юм байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

1 дүгээр асуудал.

Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах тухай протоколын төслийг хэлэлцэж эхэлье.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг та бүхэнд танилцуулъя.

Монгол Улсын Ерөнхий сайд Ням-Осорын Учрал хүрэлцэн ирсэн байна. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Буриадын Дашпүрэв, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Чулууны

Хишигдалай, мөн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Гэрээ, эрх зүй, гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Гадаад харилцаа яамны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирал Жамбалдоржийн Соёлмаа, Гадаад харилцааны яамны Хөрш орны газрын дэд захирал Дэлгэрцэцэгийн Өнөбилэг, Гадаад харилцааны яамны Олон улсын худалдаа, эдийн засгийн хэлтсийн зөвлөх Энхболд, мөн Гадаад харилцааны яамны Хөрш орнуудын газрын захирал Түвдэндоржийн Жанабазар гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байна.

Ингээд уг төслийн талаарх танилцуулгыг танилцуулна уу хэмээн Монгол Улсын Ерөнхий сайд Ням-Осорын Учрал таныг индэрт урьж байна.

Н.Учрал: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улс орны эдийн засаг уул уурхайн үйлдвэрлэлийн өсөлттэй холбоотойгоор манай улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ жил бүр өсөн нэмэгдэж, 2025 онд импортын хэмжээ 2,9 сая тонн болж, өмнөх оноос 0,1 сая тонноор өссөн байна. Цаашид 2026 онд 3 сая тонн, 2027 онд 3,1 сая тоннд хүрэх төлөвтэй байна. Өнөөдрийн байдлаар манай улс шатахууны хэрэглээгээ 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд нийт импортын 98 орчим хувийг ОХУ, үлдсэн хувийг БНХАУ эзэлж байна.

Манай гол ханган нийлүүлэгч Оросын Холбооны Улсын Роснефть компанийн 4 дүгээр сарын хил үнэ өмнөх сараас тонн тутамдаа энгийн дизель түлш 648 доллароор нэмэгдэж, 1385 доллар, евро 5, дизель түлш 483 доллароор нэмэгдэж, 1410 доллар, евро 5 АИ 92 авто бензин 441 доллароор нэмэгдэж, 1206 доллар, АИ 95 авто бензин 441 доллароор нэмэгдэж, 1176 доллар, АИ 98 авто бензин 441 доллароор нэмэгдэж, 1226 доллар болж, төрлөөс хамаарч 441-648 доллароор өссөн байна. Үүнтэй холбоотойгоор дотоодын зах зээл дээрх энгийн АИ 92 авто бензинээс бусад төрлийн шатахууны борлуулалтын үнэ энгийн дизель түлш 2200 төгрөгөөр нэмэгдэж, 5200 төгрөг, евро 5 дизель түлш 1300 төгрөгөөр нэмэгдэж 5300 төгрөг, Евро 5 АИ 92 авто бензин 1100 төгрөгөөр нэмэгдэж, 4200 төгрөг, АИ 95 авто бензин 500 төгрөгөөр нэмэгдэж, 4100 төгрөг болж тус тус нэмэгдэх нөхцөл байдал үүсээд байна.

Цаашид Ойрх дорнодын мөргөлдөөн энэ хэвээр үргэлжилж, улам хурцдаж брэнд төрлийн газрын тосны үнэ баррель нь 130ам.долларт хүрсэн нөхцөлд манай улсад нийлүүлэх дизель түлшний хил үнэ тонн тутамд 1750ам.долларт, жижиглэнгийн үнэ литр тутамд 3296 төгрөгөөр нэмэгдэх, тосны үнэ 150ам.долларт хүрсэн нөхцөлд манай улсад нийлүүлэх дизель түлшний хил үнэ тонн тутамд 2019ам.доллар болж, жижиглэнгийн үнэ литр тутамдаа 4235 төгрөгөөр нэмэгдэх, тосны үнэ 200ам.долларт хүрсэн нөхцөлд манай улсад нийлүүлэх дизель түлшний хил үнэ тонн тутамд 2693ам.доллар болж, жижиглэнгийн үнэ литр тутамдаа 6587 төгрөгөөр нэмэгдэн 1 литр дизель түлшний үнэ 9700 төгрөг болох эрсдэлтэй байна.

Манай Улс Оросын Холбооны Улсын гол үйлдвэрлэгч нийлүүлэгч Роснефть компанитай хэлцэл хийсний үр дүнд өргөн хэрэглээний бүтээгдэхүүн болох АИ 92 шатахууны хил үнийг 2022 оны 5 дугаар сараас хойш 705ам.доллароор тогтворжуулан жижиглэн борлуулалтын үнэ гадаад зах зээлээс хамааралтай үнийн өөрчлөлтгүй явж ирлээ. Манай улс АИ 92 авто бензиний гаалийн албан татвараас сардаа 9 орчим, жилдээ 100 орчим тэрбум төгрөг, дизель түлшнээс сардаа 25 орчим, жилдээ 300 орчим тэрбум төгрөгийн орлого олдог. Тэр хэмжээгээр төсвийн орлого хасагдах эрсдэл байна.

Олон улсын нөхцөл байдалтай холбоотойгоор газрын тосны бүтээгдэхүүний гаалийн албан татварын хувь хэмжээг тогтоох эрхийг Засгийн газарт олгосноор зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулж шатахууны үнийн хэлбэлзлийг түргэн шуурхай зохицуулах боломж бүрдэх өндөр ач холбогдолтой юм. Иймд “Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээг батлах тухай Монгол Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 27 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд оруулах өөрчлөлтийг Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлснээр батлах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр боловсруулан танилцуулж байна. Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Г.Тэмүүлэн: Монгол Улсын Ерөнхий сайд Ням-Осорын Учрал танд баярлалаа. Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад Төсвийн байнгын хороо болоод Эдийн засгийн байнгын хорооноос ирүүлсэн санал, дүгнэлтүүдийг танилцуулахаар байна. Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Батсүмбэрэл танилцуулна. Батсүмбэрэл гишүүнийг микрофонд урьж байна.

Н.Батсүмбэрэл: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 3 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах протоколын төслийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр ирүүлсэн билээ.

Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаараа дээрх хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах тухай протоколын төслийг хэлэлцлээ. Төсөл санаачлагчийн зүгээс хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах тухай протоколын төсөлд дараах өөрчлөлтүүдийг оруулжээ.

Хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт цогцолборын удирдах, ашиглах үйл ажиллагаа явуулна гэсэн нь нисэх буудлыг бүхэлдээ удирдах гэсэн хоёрдмол утгыг илэрхийлж байгаа тул хэлэлцээрийн өөрчлөлтийн нэмэлт протоколд энэ асуудлыг тодорхой тусгаж, “Талуудын эрх бүхий байгууллагууд нь Монгол Улсын “Чингис хаан” ОУНБ-ын агаарын хөлгийг түлшээр цэнэглэх дэд бүтцийг удирдах болон ашиглах хамтарсан компани байгуулна.” гэж Монголын талын саналаар өөрчлөлт оруулсан.

5 дугаар зүйлд “Монголын тал хамтарсан компанийн үйл ажиллагаанд Монгол Улсын дотоод зах зээлд газрын тосны бүтээгдэхүүнийг борлуулах үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийн дагуу тогтоосон хязгаарлалтууд үйлчлэхгүй байх асуудлыг хангана” гэж заасныг газрын тосны бүтээгдэхүүн гэж бүх төрлийн шатахууныг хамруулсан утгатай заалт орсон тул тодруулах, хуульд нийцүүлэх зорилгоор “Монголын тал хамтарсан компанийн үйл ажиллагаанд Монгол Улсын дотоод зах зээлд агаарын хөлгийн түлш борлуулах үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийн дагуу тогтоосон хязгаарлалтууд үйлчлэхгүй байх асуудлыг хангана” гэж өөрчлөлт оруулсан.

7 дугаар зүйлийн 1 дүгээр догол хэсэгтэй давхацсан утгыг илэрхийлж байгаа тул 2 талаас зөвшилцсөний үндсэн дээр 7 дугаар зүйлийн 2 дугаар догол мөрийг хассан.

Хэлэлцээрийн 9 дүгээр зүйлийн 2 дугаар догол хэсэгт Оросын талын арбитрын шүүх маргаан таслахаар тусгагдсан нь зохимжгүй тул гуравдагч орны арбитрын шүүхийг сонгох саналыг Монголын талаас гаргаж, хэлэлцээрийн явцад Бүгд Найрамдах Беларусь Улсын Худалдаа Аж Үйлдвэрийн танхимын дэргэдэх олон улсын арбитрын шүүх байхаар өөрчлөлт оруулсан.

Хэлэлцээрийн 11 дүгээр зүйлийн эхний догол мөрөнд Монгол Улс болон Оросын Холбооны Улсын хооронд үйлчилж буй ижил асуудал зохицуулсан бусад олон улсын хэлэлцээрээс давуу эрхтэй байна гэсэн заалт орсон тул олон улсын эрх зүйн акт, хэм хэмжээг үгүйсгэсэн, давж үйлчлэх утгатай Монгол Улсын хууль тогтоомжид нийцэхгүй байсан тул Монголын талын саналаар хассан.

Мөн хэлэлцээрийн анхны хувилбарт 20 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байх заалттай байсныг 15 жил болгож, хугацааг богиносгон өөрчлөлтүүдийг тус тус оруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа хэлэлцээрт оруулж байгаа өөрчлөлттэй холбоотой ямар эерэг болон сөрөг үр дүн гарна гэж тооцож байгаа талаар, мөн Оросын Холбооны Улстай манай улс газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтвортой байлгах гэрээ хэлэлцээр хийсний дараагаар ОХУ дахин мэдэгдэл гаргасан нь манай улсад хэрхэн нөлөөлөх талаар, Улсын Их Хурлын гишүүн Уянга хэлэлцээрт заасан хамтарсан компанийн үйл ажиллагааны талаар, цаашдаа авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд хэдэн он гэхэд дэд бүтэц бий болж тогтвортой байдлаа хангаж ажиллах талаар болон маргааныг Бүгд Найрамдах Беларусь улсын Минск хотод байрлах Беларусын Худалдаа Аж Үйлдвэрийн үйлдвэрийн танхимын дэргэдэх олон улсын арбитрын шүүхийн 2011 оны журмын дагуу хэлэлцүүлгээр шийднэ гэж тусгасан талаар, Улсын Их Хурлын гишүүн Лодойсамбуу хэлэлцээрийн 7 дугаар зүйлийн 2 дугаар догол мөрийг хассан нь нарийвчилсан тодорхой заалтыг хэт ерөнхий болгож байгаа талаар, мөн хэлэлцээр нь Монгол Улсын зах зээл болон олон талт хамтын ажиллагаанд хэрхэн нөлөөлөх талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах тухай протоколын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Лодойсамбуу тусгаар тогтносон бие даасан улс байхтай холбоотой асуудлууд дээр Монгол Улс зөв шийдвэр гаргаж байх талаар, Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг шатахууны үнэ ертгийн талаар тус тус саналаа хэлсэн болно.

Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах протоколын төслийг хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулахад Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зөвшилцөхөд дэмжиж, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Батсүмбэрэл гишүүнд баярлалаа. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд Төсвийн байнгын хорооноос ирүүлсэн санал, дүгнэлтийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 3 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсад агаарын хөдөлгөөний түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах тухай протоколын төслийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр хүргүүлсэн байна.

Төсвийн байнгын хороо 2026 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 75 дугаар зүйлд заасны дагуу дээрх хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах тухай протоколын төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ.

Хэлэлцээрт өөрчлөлт оруулснаар Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын хамтын ажиллагаа газрын тосны салбарт өргөжиж, агаарын хөлгийн түлшний хангамж нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, агаарын тээврийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд олон улсын стандартын шаардлагад нийцсэн шатахууныг тогтвортой хямд үнээр нийлүүлэх үнээр оруулж боломж бүрдэх бөгөөд тус хэлэлцээрийн 10 дугаар зүйлд заасны дагуу дээрх хэлэлцээрт өөрчлөлт оруулах протоколын төслийг боловсруулж, өөрчлөлтөд тусгасан байгаа тул Монгол Улсын Улсын Их Хурлын бүрэн эрхийн хүрээнд хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулах нь зүйтэй гэж үзсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах протоколын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлсэн болно.

Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах тухай протоколын төслийг Төсвийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсад агаар хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах тухай протоколын төслийг зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү гэсэн байна.

Ингээд Төсвийн байнгын хорооноос Наранбаатар даргаас энэхүү санал дүгнэлтийг ирүүлжээ. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу. Гишүүдийн нэрсийг авъя. Анар гишүүнээр тасаллаа. Жангабыл гишүүн асуулт асууна. Ирцийн дарааллаар юм байна. Уучлаарай Анар гишүүн түрүүлж асуулт асууна. Ганбат гишүүнээр тасаллаа.

Ч.Анар: Өдрийн мэнд хүргэе Байнгын хорооны гишүүд ээ. Энэ хуучин орж ирсэн төсөл дээр бас нэлээн хэдэн асуулт асуугаад, тэдгээр нь бас нэлээн сайн тусгагдаагүй байна л даа. Би 2, 3 асуулт байна.

5 дугаар зүйл дээр хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдолтой төлбөр, тэр дундаа Оросын талын итгэмжлэгдсэн байгууллагад оруулсан хөрөнгө оруулалтыг хураан авсны нөхөн төлбөрийг Монгол Улсын нутаг дэвсгэрээс саадгүй шилжүүлэх гэж байгаа юм. Энэ яг юу хурааж авах юм. Ямар

нөхцөлд юу хурааж авна гээд энэ ямар нөхцөлийг сэргийлээд ингэж оруулсан заалт вэ. Энэ аягүй тодорхойгүй байна. Тэгээд энэ заалтынхаа түгжээ, эрсдэлээс хамгаалж байгаа 7 дугаар зүйлийн эхний мөр доголд байна л даа. Энэ бас түрүүний анх хэлэлцэхээр оруулж ирэхэд асууж байсан.

Энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс хойш Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжид Оросын талын итгэмжлэгдсэн байгууллага болон эсвэл хамтарсан компанийн Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх цогцолборын үйл ажиллагаа болон бүх төрлийн хөрөнгө оруулалт нийлүүлэлттэй холбоотой нөхцөл байдлыг доройтоход энэ бол мэдээж гэрээгээ тогтвортой байлгахын хүрээнд хийж байгаа зүйл. Хүргэсэн тохиолдолд тэдгээр нь үйлчлэхгүй болно гэнэ. Тэгэхээр энэ өөрөө хууль зүйн дүгнэлт талаасаа Монгол Улсын хууль үйлчлэхгүй гэсэн. Үндсэн санааг нь бол ойлгож байна. Гэрээг тогтвортой байлгах. Тэгэхдээ энэ хууль зүйн дүгнэлт хийгдсэн юм уу. Ийм боломжтой юм уу. Монгол Улсын хуулийг ямар нэгэн байдлаар дараа нь өөрчилсөн хуулийг үйлчлэхгүй гээд заагаад оруулчихсан.

3 дугаарт нь 6 дугаар зүйлийн эхний догол мөрөн дээр Монгол Улсын нутаг дэвсгэрт хийсэн хөрөнгө оруулалт болон хөрөнгө оруулалт хийсний үр дүнд авах орлого. Ойлгомжтой. Тэр дундаа ногдол ашиг. Ойлгомжтой. Хувь, хүү гэж байгаа байхгүй юу. Энэ хувь ойлгомжтой. Энэ хүү гэж юу вэ. Энэ 3 асуултыг ажлын хэсгээс асууя.

Г.Тэмүүлэн: Анар гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгээс хариулна. 6 номер.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Хишигдалай. Энэ асуудал дээр ер нь зүгээр гэрээ бүхэлдээ хөрөнгө оруулалт хамтын ажиллагааны үйл ажиллагаанд ямар нэгэн саад тотгор учрах, энэ нөгөө байгуулсан анхны энэ хувилбарыг байгуулах 2022 оны намар энэ төсөл манай улсад ирсэн. Тэгэхээр энэ үед үүсээд байсан нөхцөл байдалтай холбоотой дандаа тийм сэрэмжилсэн, болгоомжилсон зүйл заалтууд орчихсон юм байна лээ. Тэгээд бид бол Их Хурлаас яг энэ догол мөрөн дээр одоо энэ 5 дугаар зүйлийн хамгийн сүүлийн догол мөрөн дээр Их Хурлаас бол санал шүүмжлэл өмнөх хэлэлцүүлэг дээр ирээгүй. Тиймээс энэ талаар бол харж үзээд, эндээ хүртэл юу гэдэг юм хөрөнгийг нь хураан авах асуудал бол гарахгүй байх гэдэг байдлаар энэ асуудлыг хөндөөгүй орхисон.

2 дахь энэ 7 дугаар зүйл дээр бол энэ Засгийн газрын хоорондын хэлэлцээрийг Улсын Их Хурлаар соёрхон батлуулахаар орох ёстой. Улсын Их Хурлаар хэлэлцүүлж байгаа учир нь энэ хэлэлцээр хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш Монгол Улсын хууль тогтоомж өөрчлөгдсөн тохиолдолд өмнөх хууль тогтоомжийн дагуу үйлчилнэ гэдэг л утгыг агуулсан. Гэрээ тогтворжуулна гэсэн санаа. Энэ бол олон улсын соёрхон баталж байгаа хэлэлцээрүүд дээр бүгд дээр нь ордог.

Энэ 6 дугаар зүйл дээр бол бас л нөгөө Оросын талын хөрөнгө оруулалт, ашиг хувь одоо яг тухайн үеийн нөхцөл байдал бол бүх барууны улс орнууд санкцад оруулаад, тус улсын хөрөнгө оруулалтуудыг царцааж байсан асуудал гарч байсан. Түүнтэй холбоотой ийм хамгаалах зүйл заалтууд тусгагдсан харагдсан. Манай дээр бол 2 улс найрсаг харилцаатай хамтын ажиллагаатай улс учраас энэндээ хүрсэн асуудал үүсэхгүй байх. Бид нар гол гол заалтууд дээрээ өөрчлөлт оруулах зарчмын байр суурьтай байсан учраас эд нараар бол оролдоогүй. Хариулж болсон.

Г.Тэмүүлэн: Анар гишүүн нэмж тодруулах уу. Анар гишүүн нэмж тодруулъя.

Ч.Анар: Энэ заалтуудын утга агуулга гэрээг тогтвортой байлгах, мөн эрсдэлээс хамгаалах гэдэг нь ойлгомжтой. Тэгж орж ирж байгаа юм. Зүгээр таны хариултаас асуултын хариултаа авч чадсангүй л дээ. Хүү ямар учиртай юм бэ. Энэ нөхөн төлбөр гэдгийг яаж үнэлэх юм бэ. Мэдээж хэн болгон л ийм байдалд орохыг хүсэхгүй. Гэтэл нөхөн төлбөр гэнгүүтээ энэ хүү энэ 2 чинь бас уягдаад байгаа байхгүй юу. Гэрээнд нарийвчилж тусгаж өгч болоогүй юм уу. Тэгэхгүй болохоороо ямар нөхөн төлбөр гэнэт бодит үнийн дүн хийсэн нөхөн төлбөрөөс нөгөө яаж үнэлэх юм. Тэр дээрээ бас тэр тохиолдолд хүү бас бодох гээд байгаа юм биш биз дээ.

Та тэр 7 дугаар зүйлийн эхнийхийг нь олон улсын гэрээ хэлэлцээрт яг жишгээр ингэж явдаг гэж ярьсан байна. Тэгэхээр энэ дээр хууль зүйн дүгнэлт гаргасан уу. Хууль зүйн дүгнэлт гаргах шаардлагатай юу. Энийг бас би Цогтбаатар даргаас асууя.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсэг Хишигдалай. 6 номер. Анар гишүүний асуултад нэмж тодруулж хариулъя.

Ч.Хишигдалай: Хэлэлцээрт өөрчлөлт оруулах ажлын хэсэг Гадаад харилцааны яам, Хууль зүйн яам, Сангийн яам, манай яамнаас хамтраад ажлын хэсэг гараад ажилласан. Энэ дээр бол хууль зүйн дүгнэлт бол гаргуулах шаардлагагүй гэж үзсэн. Их Хуралд өргөн барих зөвшөөрөл эд нар нь гол яамнуудаасаа зөвшөөрлийг нь аваад ингээд саналыг нь аваад тусгаад явж байсан. Хүүгийн хувьд бол ийм юм байна. Тодорхой хэмжээний актив хөрөнгөөр Монгол Улсад орж ирнэ. Бүтээгдэхүүнээ борлуулна. Борлуулалтын орлого банканд хуримтлагдана. Тэрний хүү гэж тодорхой хэмжээгээр бодогдоно. Тэр буцаж гарах боломж нь гэдэг утгаараа ингээд дэлгэрэнгүй орсон зүйл заалт байна. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар дарга.

Д.Цогтбаатар: Энэ олон улсын гэрээний асуудлаар Гадаад яам угаасаа хариуцсан газартай. Тэд нар өөрсдөө дүгнэлтээ гаргадаг. Манайд ерөөсөө энийг бол тэгж хууль зүйн дүгнэлт авахаар оруулж ирдэггүй. Энэ чинь ингээд л орж ирээд л Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоороо хэлэлцэгдээд л явдаг. Тэр яг явдаг журмаараа л явж байна.

Харин зүгээр түрүүн энэ залуу хариулж байхдаа нэг юм юу яаж байна лээ. Ийм нөхцөл гарахгүй, манай 2 орон сайн харилцаатай учраас ийм нөхцөл гарахгүй байх, энэ дээрээ тулахгүй байх гэж бодож байна гээд. Гэрээ хийж, хэлэлцээрийн эрх зүйн баримт бэлдсэн хүн ийм юм яриад сууж байж болохгүй шүү дээ. Яагаад гэвэл энэ чинь арилжааны гэрээ байхгүй юу. 2 орны хоорондын найрсаг харилцаа хамтын ажиллагааны гэрээ биш шүү дээ. Тэгэхээр ийм юм гарахгүй. Тийм юм гарна. Гарахаар эрх зүйн хүрээнд тэр орон том орон байна уу, жижиг орон байна уу хамаагүй яг эдийн засгийн эрх ашгаа бодож тийм муу тохиолдол гарахад яаж соёлтойгоор эрх зүйн хүрээнд шийдэх вэ гэдэг асуудлаа заавал хийх ёстой болохоос биш тийм юм гарахгүй гэж бодож та нар хийсэн бол наадах чинь ёстой байж болохгүй хариулт энд өгч байна шүү дээ. Хэн ч тэр оронтой муудалцахыг бодоогүй шүү дээ. Зүгээр бизнес бол бизнес. Энэ чинь мөнгөө төлөөд авч байгаа байхгүй юу. Ямар ч нөхцөл гар гарч болно. Гарахгүй гэж тооцож ямар нэгэн гэрээ хийж болохгүй шүү дээ.

Г.Тэмүүлэн: Болсон уу Анар гишүүн. Жангабыл гишүүн асуулт асууя.

Х.Жангабыл: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай энэ хэлэлцээрийг 100 хувь дэмжиж байна. Ямар ч асуудалгүй. Энэ гэрээг бол хангалттай бид ярилаа. Яах вэ гишүүд их эрсдэлээ бодож байна л даа. Зөв л дөө. Гэхдээ энэ хэлэлцээр харьцангуй эрсдэлгүй гэж үзэж байна. Яагаад гэхээр Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний жилийн нийлүүлэлтийн 2,6 хувийг л энэ агаарын хөлгийн түлш эзэлж байгаа. Харьцангуй бага хэмжээ.

2 дугаарт бид сайн, муу ч гэсэн дотооддоо газрын тос боловсруулах үйлдвэрийн барилга, угсралтын ажлыг хийгээд 2027 оны 4 дүгээр улиралд ашиглалтад өгнө. Энэ үед энэ үйлдвэрээс бас агаарын хөлгийн түлшийг бол нийлүүлнэ. Тэгэхээр харин ч 2 эх үүсвэртэй, дотоод, гадаад гэсэн сайн талтай. Эрсдэл бол бараг байхгүй гэж хэлж болохоор. Энэ хэлэлцээрийг байгуулснаар бас давуу талтай гэж харж байгаа.

1 дүгээрт Оросын Холбооны Улс байсхийгээд л газрын тосны бүтээгдэхүүний экспортоо хаачихдаг. Гэхдээ манай улсад бол энэ экспорт нь бол үйлчилдэггүй. Газрын тосны нийлүүлэлт, найдвартай байдлыг байнга хангасаар ирсэн.

2 дугаарт бол энэ хэлэлцээрийг баталснаар газрын тосны хил үнэ бол асар их нэмэгдсэн шүү дээ 4 дүгээр сард. 5 дугаар сард бүр нэмэгдэхээр байна. Энэ хил үнийг бас ярих боломж бололцоо бас төрөх болов уу л гээд бодож байна. Манай яамныхан зөв биз дээ. Дээрээс нь ямар ач холбогдолтой байж болох вэ бас яамныхнаас нэг асуулт байна. Энэ хэлэлцээрийг гишүүд ямар ч эрсдэл байхгүй шууд батлаад л явуулах хэрэгтэй. Бид бол хангалттай ярилаа. 1 удаа буцаалаа. Эрсдэлийг бодоод гишүүдийн санаа зовж байгаа нь зөв л дөө. Гэхдээ харьцангуй бол эрсдэл бага байгаа юм. Давуу талуудыг нь бас нэрлээд явчихвал манай яамныхан.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсэг Хишигдалай 6 номер.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Хишигдалай. 2024 онд Монгол Улс 2 газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх салбарт Оросын Холбооны Улстай хамтарч ажиллах, агаарын хөлш хөлгийн түлш нийлүүлэх салбарт Оросын Холбооны Улстай хамтран ажиллах 2 хэлэлцээрийг байгуулсан байдаг юм. Эхний хэлэлцээр дараагийн хэлэлцээр 2 хамтдаа байхдаа хүчин төгөлдөр үйлчилнэ гэдэг албан бичгээр харилцаж ингэж явдаг. Эхний хэлэлцээр бол Монгол Улсад ашигтай. Засгийн газрны хүрээнд шийдээд явах боломжтой. Татвар, хөрөнгө оруулалтын орчны талаар ямар нэгэн хууль, эрх зүйн орчны өөрчлөлтийн талаар дурдсан зүйл, заалт байхгүй. Энэ хэлэлцээрийг бол Засгийн газрын процедураа гүйцээгээд албан ёсоор албажаад явчихсан. Гэтэл Оросын тал маань юу ярьдаг вэ гэвэл 2 адилхан хэлэлцээрийн нэгийг нь баталчхаад, нөгөөг нь та бүх бүхэн батлахгүй байна. Энэ 2 чинь 1 салбарын хэлэлцээр хамтдаа байж байж хүчин төгөлдөр. Дараагийн хэлэлцээрээ баталж ирүүлэхгүй бол бид энэ газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх хэлэлцээрээ хүчин төгөлдөр гэж үзэхэд бас хүндрэлтэй нөхцөл байдал үүсэж болзошгүй шүү гэдэг байдлаар ханддаг.

Энэ өмнө нь 2024 онд байгуулсан энэ бүтээгдэхүүн нийлүүлэх салбарт ажиллах энэ гэрээнийхээ үр дүнгээр бид нар 2024 оноос хойш улирал болгонд

Оросын Холбооны Улсын энэ тавигдаж байгаа бүтээгдэхүүний экспортын хоригийг тойрч ирсэн. 2024 оны хавар тавигдсан, 2025 оны хавар тавигдсан, намар бас тавигдсан. Одоо 2026 онд 4 сарын 1-ээс 7 дугаар сарын 1 хүртэл бас хориг арга хэмжээнүүд ингээд тавигдаж байна. Гэтэл бид бол 2 улсын Засгийн газар хоорондын байгуулсан хэлэлцээрийн үр дүнд энэ хоригт ямар нэгэн байдлаар орохгүй. Бүтээгдэхүүн хангамжийн хувьд бол найдвартай эх үүсвэрээс аваад ингээд явж байна.

2-т бид 92 авто бензин дээр бол тогтвортой байдлын урт хугацааны гэрээ байгуулчихсан. Жил болгон сунгаад энийгээ хэрэгжүүлээд явж байна. Өнөөдөр 92 авто бензин дэлхийн зах зээл дээр бол 1200 ам.доллороор тонныг нь худалдаж авч байна. Бид бол энэ тогтвортой гэрээ хэлцлийнхээ үр дүнд болбол 705 ам.доллороор буюу даруй 70 хувь хямд үнээр, тогтвортой 92 авто бензинийг аваад явж байна. Энэ нь бас үр дүнгээ өгөөд импортын алдагдлын хувьд ч гэсэн ард иргэд, аж ахуйн нэгжийн хувьд ч гэсэн тодорхой хэмжээний ашгаа өгөөд явж байна гэж үзэж байна.

Энэ 2 хэлэлцээр батлагдаж, соёрхон батлах процедураа гүйцээснээр цаашид Монгол Улс бол ямар ч байсан импортын найдвартай эх үүсвэртэй байна. Ямар нэгэн асуудал үүссэн тохиолдолд бид нийлүүлэгч улсаасаа хариуцлага нэхэх эрх зүйн орчин бүрдэх юм.

Г.Тэмүүлэн: Жангабыл гишүүн нэмж тодруулъя.

Х.Жангабыл: 2024 онд бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулсан гэсэн үү. Тэр гэрээг хүргүүлэх боломж байна уу. 1 дүгээрт.

2 дугаарт хил үнийг ярих боломж байна уу. Энэ хэлэлцээр байгуулагдсанаар хил үнэ гээд нэг аюултай үнэ ирчхээд байгаа шүү дээ.

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. 6 номер. Хишигдалай:

Ч.Хишигдалай: 2024 оны 9 сард Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх салбарт хамтран ажиллах хэлэлцээрийг байгуулсан. Энэ хэлэлцээрийг бол Улсын Их Хурлын гишүүн танд хүргүүлэх бүрэн боломжтой.

Хил үнийн хувьд бол ярих боломжтой. Гэхдээ бидэнд одоо 92 авто бензинийг бол маш хямд, тогтвортой үнээр нийлүүлж байгаа. Дараагийн бүтээгдэхүүнийхээ үнийг ярилцахаар зарчмын саналыг бол хүргүүлсэн. Ярилцахад бэлэн гэдгээ илэрхийлсэн. Эргээд асууж байгаа асуулт бол өмнө нь явж байсан хэлэлцээр маань хаана явна вэ, ямар түвшинд явна вэ, хэзээ хариугаа өгөх вэ гэдэг асуулт тавьж байгаа учраас бид бас энэ хэлэлцээрийг зөвшилцөх асуудлыг яаралтай байдлаар оруулж ирж байгаа. Бид өнөөдөр шийдвэр гаргаж чадвал эргээд ярилцах нүүртэй, асуудлаа ярилцаад явах бүрэн боломжтой.

Г.Тэмүүлэн: Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууя.

Д.Ганбат: Нэлээн тийм эрсдэлтэй гэрээ хэлэлцээрийг л оруулж ирээд байна л даа. Тэгээд энэ дээр чинь юу байна шүү дээ. Өнөөдөр дэлхийн нөхцөл байдал, бид нарын нөхцөл байдал ер нь цаг, минутаар өөрчлөгдөж байна л даа. Тэгээд яг ийм хүнд хэцүү үед ийм гэрээ хийх шаардлага байна уу, байхгүй юу. Одоо бид нарын гол хүлээсэн тэр газрын тосны үйлдвэр ашиглалтад орох хугацаа нь ямар байх юм.

Энэ чинь одоо 20 байснаа 15 жил болсон юм байна. Өшөө үүнээс өөр багасгаж болох боломж бололцоо байсан уу, байгаагүй юу. Энэ 10 жил эрх барьж байгаа сүүлийн үед дангаараа хэтэрхий олонх болчихсон байсан нам маань ингээд янз бүрийн юмнууд нь гарч ирж байна л даа түрүүчээсээ. Одоо бидний хөрш Хятад улс гэхэд л одоо юу байна шүү дээ. Бүтэн жилээрээ нөөцөө бэлдчихсэн. АНУ гэхэд 2, 3 жилээрээ нөөцөө бэлдчихсэн. Тэгээд бид нарын нөөц ямар байгаа вэ. Яг юу байна. Өдий хүртэлх хугацаанд юу хийж байсан бэ. Тэр агуулах сав бариад ашиглалтад оруулахгүй юу хийж байсан юм. Яаж байсан юм. Бидний гашуун туршлага байна. Тэр бусад гадаад орнуудтай, улстай хэлэлцээ хийдэг. Дараа нь төлбөрт ордог. Тэгээд Монголын ард түмэн хохирч байдаг. Тэгээд манай 2 хөршийн болон хэлсэн ярьсандаа хүрдэггүй. Тэр амандаа хүрдэггүй болохоор бүр хатуу гэрээний зүйл заалт дээр гар хөлийн үсгээ зурдаг. Тэгээд иймэрхүү л байдалтай байна. Яг л ийм юм болох гээд байгаа юм биш үү. Тухайлбал, би тэр тэр ураны гэрээг хэлэх гээд байна. Дараа нь бид нар 70 саяын юунд унасан шүү дээ. Оросын Холбооны Улс маань өнөөдөр цэргийн тусгай ажиллагаа хийж байгаа. Энэ бол дайны байдалд байгаа шүү дээ. Тэгээд дайны байдалд байгаа улс орон бол ямар ч гэрээ хэлэлцээр, ямар ч байдалд орж болно шүү дээ. Ийм хөнгөлөлттэй үнэтэй хийчихсэн. Энэ бол баталгаатай энэ тэр гээд ард түмнийг тайван байдал руу та нар бас оруулж болохгүй. Энэ бол эрсдэлтэйгийн эрсдэлтэй байхгүй юу. Өдөр болгон тэр хангамжийг нь нөгөө байлдаж байгаа улс орнуудад дроноор дайрч довтолж байна. Манай өмнөд хөрш маань ямар ч бензин шатахуун гадагшаа гаргахгүй гэдэг тушаал шийдвэрээ гаргачихлаа. Ийм юмаа та нар ойлгож байна уу, үгүй юу. Нэг л баахан улс төржчихсэн хүмүүс.

Яг одоо хэзээ хэзээнээс илүү энэ Монгол Улсын 2 багана болсон. МАН, АН 2 бол хамтарч ажиллах ёстой байхгүй юу. Бүх талаар ойлголцож. Энэ бол одоо бараг л түүхийн захиалга шахуу болчихоод байна шүү дээ. Тэгэхгүй одоо тэгээд авлига, албан тушаал, энэ бүх юмандаа барьцаалагдсан. Ийм юмаар явж болохгүй шүү гэдгийг хариуцлагатай хэлж байгаа шүү. Оюун-Эрдэнийн Засгийн газар 5 жил ажиллахдаа юу хийсэн юм бэ. 105 их наяд мөнгө зарцуулчихсан байдаг. Өмнө байсан бүх засгийн газруудыг нийлүүлсэн хэмжээтэй. Тэгээд авлига, албан тушаалын тийм хэргийн нэг хэсэг болсон. Харин Занданшатарын Засгийн газар одоо 9 сар ажиллаад л уналаа. Энэ хооронд авлига, албан тушаалтай зоригтой тэмцэж чадахгүй байсаар байгаад л дууслаа шүү дээ. Манай энэ Учрал даргын Засгийн газар битгий тийм болчихоосой. Энэ хэзээ хэзээнээсээ илүү түүхийн, нийгмийн захиалга болчихоод байна шүү нөхөд минь. Тэгэхгүй нөгөө Засгаа байгуулаад л ингээд л яваад л өдөр хоног өнгөрөөгөөд л хэдэн дарга нар, албан тушаалтай үлдэнэ. Тэгээд иймэрхүү гэрээ хэлэлцээрийг бид нар батлаад, дэмжээд л. Зөвхөн өнөө маргаашаа харсан нөхцөлд ийм хүнд байдал руу шилжээд байж болохгүй ээ. Би бол тэгж үзэж байна.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсэг 6 номер. Хишигдалай.

Ч.Хишигдалай: 2025 оны хавар хэлэлцээрийг зөвшилцөхөөр Улсын Их Хуралд хүргүүлээд, 4 дүгээр сард холбогдох Байнгын хороогоор хэлэлцүүлсэн. Байнгын хороод Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн саналын дагуу өөрчлөлт хийх зайлшгүй шаардлагатай юм байна гээд бид саналыг ОХУ-д хүргүүлээд, Байнгын хорооноос уг хэлэлцээрийг татан авсан. Үүнээс хойш бол бид хэлэлцээрт аль болох Монголынхоо талын саналуудыг тусгахаар өөрсдийн зорьсон хүссэнээр найруулахаар ингэж аль болох чадлаараа ажилласан. Боломжоороо ажилласан. Оросын тал бол хэлэлцээрт ямар нэгэн байдлаар өөрчлөлт оруулахгүй гэдэг хатуу байр суурийг бол байнга илэрхийлж байсан. Өнгөрсөн хугацаанд 2025 оны 9 дүгээр

сараас хойш Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, албаны хүмүүс бол Оросын Холбооны Улстай хийсэн уулзалт болгон дээр бид энэ асуудлыг заавал хөндөх ёстой. Бид хөндөж чадахгүй л бол энийг цааш нь явуулах боломжгүй гэдэг зарчмын байр суурийг байнга илэрхийлж явсны үр дүнд 10 дугаар сараас хэлэлцээрт бас тодорхой хэмжээний өөрчлөлтүүд оруулж болох юм гэдэг талаар яриа хэлэлцээрүүдийг эхлүүлсэн. Ингээд хэлэлцэж явсаар байгаад 2026 оны 1 дүгээр сард хэлэлцээрийн эцсийн байдлыг бид нар албаны шугамаар ингээд солилцсон учраас өнөөдөр Улсын Их Хурлын чуулган нээгдэнгүүт орж ирж байна. Бид бол энийг ингээд бүтэн 1 жил хагасын хугацаанд ингээд хэлэлцэж явж байгаа. Цаг хугацааны хувьд бол өнөөдөр орж ирж байна.

Нөөцийн хувьд бол Монгол Улс өнөөдөр АИ 92 авто бензиний 42 хоногийн нөөцтэй байна. Дизель түлшний 28 хоногийн нөөцтэй байна. Монгол Улсын хэмжээнд бол 27, 28 хоногийн хэмжээний бүтээгдэхүүнийг хадгалах агуулахын хүчин чадалтай байна. Уг агуулахыг нэмэгдүүлэхээр тодорхой хэмжээний аж ахуйн нэгжүүдийг идэвхжүүлээд ажиллаж байна. Энэ ондоо багтаад бид энэ хүчин чадлыг 15-30 хоногоор нэмэгдүүлэх боломжтой гээд аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа эхлээд явж байна.

Эөөцлөх сав байхгүйн улмаас өнөөдөр Монгол Улсын төмөр зам дээр ялангуяа энэ Толгойт өртөө дээр мянга орчим вагон буулгах ээлж дарааллаа хүлээгээд, тэгээд сав хоосрохыг хүлээгээд зогсож байна. Дараа дараагийн вагонууд араасаа орж ирээд ингээд явж байна. Аль болох дотоодын аж ахуйн нэгжүүд бол боломжоороо зохион байгуулалтад ороод, маш эрсдэлтэй энэ нөхцөл байдлыг хатуу ойлгоод ажиллаж байгаа.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүн тодруулъя.

Д.Ганбат: Нөхөд минь та бүхний тэгээд ажлаа хийж байгаа байдал нөхцөл чинь ийм л байна шүү дээ. Гэхдээ тэгээд нөхцөл байдлыг бас түрүүчээс нь үнэн зөвөөр хэлж байх нь зүйтэй ард түмэндээ. Бэлтгэлтэй байг. Хар л даа одоо энэ гэрээ хэлэлцээр чинь болохоо байгаад арбитрт хандахад Оросын Холбооны Улсын Москва хотын арбитрт хандана л гэж байна шүү дээ. Энэ Улаанбаатарт чинь Арбитр байдаг биз дээ. Тэгээд бүр болохоо байвал Беларусь гэж байна. Үгүй ээ, ийм юм хийгээд байж болохгүй шүү дээ энэ чинь. Арай жоохон олон улсын маягтай, улс орныхоо эрх ашгийг бодсон ийм зүйл хийж болоогүй юм уу. Энийг ахиж үзсэн нь дээр. Ахиж ярих хэрэгтэй.

Агуулах савныхаа байгаа байдлыг хар л даа та нар. Ийм олон жил ийм л юм хийсэн байна шүү дээ. Тэгээд л баахан дарга цэрэг болох гэсэн хүмүүс гүйгээд байна..../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Гэрээний асуудлаар хаанаас хариулах вэ. 8 номер.

Ж.Соёлмаа: Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирал Соёлмаа байна. Арбитрын шүүхийн талаар асуултад товч хариулъя. Ганбат гишүүний онцолсноор бол энэ Оросын Холбооны Улсын арбитр гэсэн ийм бичвэртэй анхдагч бичвэр дээр байсан. Өмнөх хэлэлцүүлгийн үеэр нэг талыг барьсан Оросын талын арбитр байх нь зохимжгүй гэсэн ийм санал шүүмжлэлүүд ирсэн. Түүний дагуу Оросын талтай нэмэлт, өөрчлөлтийн протокол дээр удаа дараа санал тавьсан. Оросын талаас бол угаасаа Оросын Холбооны Улсын хөрөнгө оруулалттай ийм төрийн өмчит компанийн хувьд бол энэхүү саналаа өөрчлөхгүй.

Арбитрынхаа юуг өөрчлөхгүй гэсэн ийм саналууд илэрхийлж байсан. Тэгээд 3 дахь раундын хэлэлцээр дээр гуравдагч талын арбитрыг сонгоё гэсэн хүсэлтийг удаа дараа илэрхийлсний дагуу Беларусын олон улсын арбитрын шүүхийг сонгохоор талууд зөвшилцөлд хүрсэн. Беларусын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх олон улсын арбитрын шүүхийн хувьд гэх юм бол 1994 онд байгуулагдсан. Бүс нутагтаа төдийгүй олон улсад тодорхой хэмжээний хүлээн зөвшөөрөгдсөн ийм олон улсын арбитрын шүүх байгаа. Тэгээд олон улсын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай Нью-Йоркийн конвенцын гишүүнчлэлийн хувьд олон улсын ийм арбитрын үйл ажиллагааг явуулдаг стандартад нэгдсэн ийм шүүгч учраас бид нар хүлээн зөвшөөрсөн байгаа.

Г.Тэмүүлэн: Гантөмөр гишүүн асуулт асууя.

Л.Гантөмөр: Ингээд энэ асуудал бүтэн жил яригдаад байгаа юм. Тэгээд бид нар жилийн өмнө ярьж байсан үед яригдаж байсан ситуац бол улам хүндрээд байгаа юм. Жилийн өмнө бид нар бол энэ түлшний хангамжийг тогтвортой байлгая гэдэг үүднээс Засгийн газар, Их Хурал руу оруулж ирсэн. Их Хурал бол хойшлуулсан. Үүнийхээ үр дүнд намар баахан түлш тасарсан. Тэгээд өөрсдөө болохоор зэрэг бид нар захиалгаа өгөөгүй юм байна лээ гээд эзэн биегүй. Одоо хариуцдаг хүн байхгүй. Өвөл хамаг амьтныг хөлдөөж алахаа шахсан. Бензинд ямар олон цаг очерлолоо. Одоо бүгдээрээ тэрийг мартчихсан. Тэр дээр одоо хариуцлага хүлээдэг хүн байхгүй.

Тэгээд би Цогтбаатар даргаас асуумаар байгаа юм. Яг одоо иймэрхүү гэрээг ингээд Их Хурал яриад байдаг. Цаашдаа байж болж байна уу. Одоо жишээлбэл энэ гэрээг Оросын ДУМ ярих уу. Энийг Аюулгүй байдлын байнгын хороо, Хууль зүйн байнгын хороо ер нь энэ хэлэлцээрүүдийг цаашаагаа яаж хийх учиртай юм бэ. Засгийн газрын түвшинд нь үлдээх юмыг нь үлдээгээд, компаниудад нь үлдээх юмыг нь үлдээгээд, тэгээд бид өөр дээрээ авдаг ачааллаа авахгүй бол энэ баахан популистууд өнгөрсөн жил самарсан шүү дээ. Тэгээд одоо намайг бол жишээлбэл Оросын тагнуул болгож хувиргасан. Яг энэ суудал дээр сууж байгаад над руу дайрч байсан хүмүүс өнөөдөр энэ асуудлыг яриад явж байгаа юм л даа. Тэгээд бараг үйлийн үрээ эдэлж байгаа байхгүй юу. Тэгээд бодит үнэн бол бид Монголын ард түмнийг түлшээр тасалж болохгүй. Ийм зүйл дахиад цаашаагаа давтагдахгүйн тулд өнөөдөр бол их ичмээр байдалд орж байгаа шүү дээ. Ираны хоолой, Ормуз-ын хоолой хаагдангуут одоо яаралтай юмыг нь хийж өгье гээд ингээд олон улсын харилцаан дээр Монгол Улсыг маш ичгэвтэртэй байдал руу ингээд чихдэг. Тэгээд энэ юман дээр Цогтбаатар дарга Гадаад хэргийн сайд байсан хүн ер нь нэг бодлого бодох ёстой юм биш үү гэж би танаас асуумаар байгаа юм.

Тэгээд Гадаад бодлогын байнгын хорооны дарга ч гэсэн ер нь цаашаагаа бид нар ийм хэлэлцээрүүд их олныг хийх шаардлага гарна. Дэлхий даяараа дайн болно. Болж байгаа бидний оролцоогүйгээр. Бүх улсууд ялангуяа том гүрнүүд бүгдээрээ дайнд татагдаж орно. Энэ хүмүүс дайнд татагдаад орохоор бид нар бүгдтэй нь төвийг сахисан ямар нэгэн худалдааны хэлэлцээрүүд хийж таарна. Ард түмнээ өсгөхгүйн тулд, улс орныхоо эдийн засгийг авч гарахын тулд. Тэр болгон Их Хурал дээр орж ирээд популизм болоод байвал бид цаашаагаа яах вэ гэдэг ийм маш ноцтой асуудал яригдаж байгаа байхгүй юу энэ чинь. Агаарын хөлгийн түлш ярихдаа улс хоорондын харилцаа яригдаж эхэлдэг. Тэгээд хэдэн вагон бензин ярихаар зэрэг олон улсын асуудал болж хувирдаг. Тэгэхээр бол бид нар ер нь Их Хурал юугаа ярьдаг байх юм. Засгийн газар яг ямар эрх мэдэлтэй байх юм. Сайд нь яг юу мэдэх юм. Одоо жишээлбэл, би Цогтбаатар даргаас дахиад асуумаар байгаа

юм. Ер нь энэ гадаад худалдааны асуудал чинь ингээд Аж үйлдвэрийн яам дээр байх зохилтой юу. Одоо надад бол энэ маш их эргэлзээ төрүүлж байгаа юм. Аж үйлдвэрийн сайд гээд дотооддоо юм үйлдвэрлэдэг нөхөр гадна талынхаа улс оронтой худалдааны гэрээ хийгээд байхаар энэ болох уу, болохгүй юу гээд ийм ийм асуудлууд бол байна. Тэгээд .../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Гантөмөр гишүүнд 1 минут нэмж өгье.

Л.Гантөмөр: Мэдээж хэрэг энд асуудлаа оруулж ирж байгаа энэ төрийн албаны хүмүүс дээр бол янз бүрийн ярих юм алга. Яагаад гэвэл энэ чинь 2 талын хэлэлцээрийг бид нар эндээс загнаад, чи тийм болго гэхлээр манай хэд гүйж очоод тийм болгодог ч юм биш л дээ. Ямар сайндаа л жилийн дараа юм оруулж ирж байна. Оруулж ирэхдээ би Монголд ашигтай хийсэн гэж худлаа ярих гэж байгаа байхгүй юу. Одоо энэ төрийн албаны хүмүүсийг бид нар өөрсдөдөө зориулаад худлаа яриулдгаа болимоор байна. Зүгээр энэ дээр бол Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга орж ирээд маш хариуцлагатай л яримаар байгаа байхгүй юу. Уг нь бол энэ Байнгын хороон дээр. Бид гадаад талдаа, гадаад худалдаа талдаа Оросын түлшнээс бүрэн хараат байгаа. Тэгэхээр бол тогтвортой энэ бензин түлшээ авахын тулд Хятадаас уг нь бид нар жоохон 30 хувийн түлш авъя гээд явж байсан чинь Хятад маань түлшгүй болчихлоо. Тэгээд аюулгүй байдлаа хангахын тулд бид Аюулгүй байдлын байнгын хороондоо хандаж байна. Энэ гэрээг та бүхэн хэлэлцэж өгнө үү гэж ингэж л яримаар байгаа байхгүй юу. Одоо үнэнийг ярихгүй бол одоо бөөн худлаа юм..../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Ерөнхийдөө бол санал. Цогтбаатар дарга дараа нь үг хэлж болно. Тэгэхдээ тодорхой бас байр сууриа илэрхийлж бас болох байх. Ажлын хэсгээс бол нэмж хэлэх зүйл байхгүй байх. Тулга гишүүн асуулт асууя.

Б.Тулга: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье. Гантөмөр сайдын хэлж байгаатай ер нь бол санал 1 байгаа юм. Бид нар энэ нефтийн бүтээгдэхүүн энэ дотроо агаарын түлш, бүх төрлийн нефтийн газрын тосны бүтээгдэхүүнийг бол Оросын Холбооны Улсаас л 100 хувь хангаж байгаа шүү дээ. Авч байгаа. Бүх дэлхий тийм байгаа. Тэгээд санкад ороод Европын Холбоо жишээлбэл Оросоос авахгүй, янз янзын нөхцөл байдалд байгаа учраас авахгүй гэж байгаа юм алга байна шүү дээ. Тэгээд хулгайгаар ч хамаагүй Энэтхэгээр дайруулаад авч байна. Тэгэхээр бид нар бол нэгэнт л хараат юмаа бас хүлээн зөвшөөрөөд, тогтвортой 2 хөрштэйгөө эв найрамдалтай худалдааны энэ гэрээгээ хийхээс өөр арга байхгүй. Энийг цаашаа дахиж гацаа ч гэдэг юм уу, зогсоох хэрэг байхгүй. Гишүүдийн хэлж байгаа болгоомжлох зүйлийг мэдээж тусгах ёстой. Тэгээд ажлын хэсэг маань бас энэ дээр сайн ажиллаад бас тодорхой саналуудыг тусгуулаад хэлэлцээр хийгээд ирсэн нь бол сайн байна. Мэдээж энэ амаргүй ажил байдаг. Яг өнөөдрийн байдлаар Кореа Айр гэж компани бол одоо эрсдэлийн удирдлагын горим гэдэг ийм хүнд горим руу жишээлбэл энэ том агаарын компани орчихсон явж байна шүү дээ. Зөвхөн энэ онгоцны түлшний үнийн өсөлттэй холбоотойгоор Солонгосын компани өөрийнхөө үйл ажиллагааг хязгаарлагдмал эрсдэлийн удирдлага руу шилжүүлээд явж байгаа энэ нөхцөлд Монгол Улс хөрш орноосоо энэ нефтийн бүтээгдэхүүн худалдааныхаа гэрээг тогтвортой байдлаар хийх нь бол маш чухал юм.

Тэгээд миний асуулт бол энэ Чингис хаан нисэх онгоцны буудал манай агаарын боомт дээр зөвхөн хийгдэж байгаа гэж би ойлгож байгаа. Цаашлаад Өмнөговь дээр юм уу, Дорнод дээр, Ховд дээр, Хөвсгөл дээр шинэ агаарын боомтууд нээгдэхэд энэ компаниуд тэнд үйл ажиллагаа явуулж, өөрөөр хэлбэл энэ

гэрээгээр зохицуулагдах уу. Аль эсвэл үүнээс тусдаа байгаа юу гэдэг ийм асуултыг та бүхнээс асуух гэсэн юм.

Г.Тэмүүлэн: Тулга гишүүний асуултад хариулъя. Аж үйлдвэрийн яам. 6 номер.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Газрын тосны бодлогын газрын дарга Хишигдалай. Хэлэлцээр бол ерөөсөө шинэ нисэх онгоцны буудлыг ашигтай ажиллаж, түүгээр онгоцны түлшийг нийлүүлэх л хүрээнд хийгдэж байгаа хэлэлцээр. Бусад авиа боомт, аэропортууд бол үүнд хамаарахгүй.

Г.Тэмүүлэн: Болсон уу. Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Байнгын хорооны эрхэм гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Би одоо бол Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын хувьд биш, Улсын Их Хурлын гишүүний хувьд та бүгдэд бас хэдэн үг хэлье гэж бодлоо. Хуулийн тодорхой зохицуулалтаас шалтгаалаад би бас та бүгдийн хариултад хариулах боломжгүй ийм байгаад байгаа юм. Агаарын хөлгийн түлшний хэлэлцээр 1 дүгээрт яагаад чухал вэ гэвэл манай улс нийт импортынхоо газрын тосны бүтээгдэхүүний импортынхоо 97-98 хувийг Оросын Холбооны Улсаас авдаг. Оросын Холбооны Улсаас нийлүүлдэг компаниуд нь бүгд төрийн өмчит аж ахуйн нэгжүүд байдаг. Роснефть, Газпром гээд том хэмжээний төрийн өмчит аж ахуйн нэгжүүд байдаг. Тийм учраас Оросын Холбооны Улсаас одоо байгаа нөхцөл байдлаасаа шалтгаалаад хориг арга хэмжээ, янз бүрийн арга хэмжээ авдаг. Одоо ч гэсэн дизель түлш болон АИ 92 авто бензин дээр экспортын хоригтой байгаа. Энэ экспортын хоригийг тойрч гаргахын тулд бид Засгийн газар хоорондын хэлэлцээр зайлшгүй хийх ёстой гэдэг ийм одоо шаардлагатай байдаг.

Энэ хэлэлцээрийн 2 дугаар ач холбогдол бол Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүнийг тогтвортой, тасралтгүй нийлүүлэх 2 дахь хавсралт гэрээ байгаад байгаа. Энэ гэрээ хүчин төгөлдөр болох нөхцөл бүрдэх юм байгаа юм. Тэгэхээр энэ гэрээний одоо зайлшгүй хүчин чадал, хэрэгцээ нь бол энэ байгаад байна.

3 дугаар асуудал өнгөрсөн оны хавар 2025 оны хаврын чуулганаар энэ асуудал орж ирэхэд Улсын Их Хурлын Байнгын хороод дээр 6 асуудал яригдсан.

1 дүгээрт Хөшигийн хөндийн нисэх буудлыг тэр чигт нь менежментээр өгөх гэж байна гэдэг асуудал тодорхой бус ойлгогдохоор ийм заалтууд орж ирсэн байсан.

2 дугаарт жил нь их урт байсан.

3 дугаарт арбитрыг ОХУ шийднэ гэдэг ийм асуудлууд байсныг өнгөрсөн 9 сарын хугацаанд өөрийн биеэр 5 удаа, Оросын Холбооны Улсын тал Монголд 1 удаа 6, цахимаар 3 удаа хуралдаж байж үндсэндээ сар болгон гэсэн үг. Тасралтгүй ярьж явсаар байгаад энэ гэрээг 6 асуудлын 5-ыг нь Монголын саналаар, өөрсдийнхөө саналаар томъёолуулж чадсан. Ганцхан асуудал үлдсэн. Тэр нь Их Хурлаар орж шийдэгдэх ёстой юм. Юу вэ гэхээр энэ гэрээг олон улсын гэрээ хэлцэл гэж хүлээн зөвшөөрнө шүү гэдэг утгатай л ийм заалт нь Их Хурлаар орох ёстой байгаа. Одоо ингээд та бүхэн маань дэмжиж гаргаж өгвөл бид нар Оросын Холбооны Улстай дараагийн Засгийн газрын төлөөний хүн ингээд яваад, зураад ингээд Их Хурлаар ороод эцэслэгдэнэ.

Эцэст нь хэлэхэд би Гантөмөр гишүүнтэй санал 100 хувь нэг байна. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын хариуцдаг хүрээнд цөмийн энерги, газрын ховор элемент, чухал элемент гээд чухал асуудлууд, дээр нь нэмээд энэ шатахуунтай холбоотой асуудал байх бол туйлын зохимжгүй байгаад байдаг юм. Тэгэхээр энийг бол Эрчим хүчний яам уу эсвэл гадаад харилцаа, яг гадаад худалдаа хариуцдаг хүмүүс энийг хариуцах нь бол зүй ёсны асуудал юм байна лээ. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам бол стандарт дотоодын асуудлаа шийдэх тал дээр анхаарах нь зөв юм байна гэдэгтэй бол тантай 100 хувь санал нэг байна.

Тэгээд эрхэм гишүүд та бүхэн бас ойлгож, дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хэлэлцээр болоод хэлэлцээрт өөрчлөлт оруулах протоколын төсөлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байна уу. Гантөмөр гишүүнээр тасалъя. Гантөмөр гишүүн.

Л.Гантөмөр: Ер нь бол би дэмжиж байгаа. Дэмжинэ. Яагаад гэвэл би жилийн өмнө бас дэмжиж байсан юм. Тэгээд байр суурь бол өөрчлөгдөхгүй. Ер нь Их хурлын гишүүний ёс суртахуун яриад байгаа юм. Тэр нэг пого хийсэн байх, хараал хэлсэн байх гэдэг юмаар хязгаарлагдаад байгаа юм. Их Хурлын гишүүний ёс суртахуун гэдэг бол ерөөсөө энэ. Байр суурь байх ёстой. Цаг хугацаанд шахагдаж байр сууриа өөрчилдөг эсвэл улс орны асуудлыг хүндрүүлж байж байр сууриа өөрчилдөг, эсвэл бүлэг фракцаасаа болоод байр сууриа өөрчилдөг. Энийг л ёс суртахуун гээд байгаа юм. Энийг л Их Хурал дахь Ёс зүйн дэд хороо ярьж байх хэрэгтэй юм байгаа юм. Энийг популизм гээд байгаа юм.

Тийм учраас бол би ийм популизм, ийм ёс суртахууны зөрчил рүү олон улсын харилцааг оруулахгүйн тулд яах вэ гэдгийг Тэмүүлэн даргыг бодож боловсруулаасай гэж үг хэлмээр байгаа юм. Энэ дээр бол их нарийн бодлого бодож байж, манай Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо бол ажил үйл нь нэлээн цэгцрэх юм байна лээ. Тэгэхгүй бол одоо Хятад улстай нэг яриа хийдэг, Хятадын парламент хуралдаагүй байхад манайх энд хуралдаад байдаг. Оростой нэг яриа хийдэг. Оросын парламент хуралдаагүй байхад бид энд хуралдаад байдаг. Тэгэхээр бол энэ Засгийн газарт ямар эрхийг нь өгч байх юм бэ. Бид ер нь юугаа, ямар түвшинд юмаа ярих вэ гэдгээ их тодорхой болгож авахгүйгээр цаашаагаа явах юм бол ийм популизм буюу ёс суртахууны зөрчил рүү Монголын парламент ороод, үүнээсээ болоод дэлхий дахинд нэр хүндээ алдаад байгаа юм. Одоо Оросын Холбооны Улстай янз бүрийн юм ярихаар маш хэцүү шүү дээ. Хэлсэн, ярьсан юмаа ерөөсөө хийдэггүй. Баахан том ярьдаг. Ерөнхий сайд уулзахаараа баахан том юм ярина. Ерөнхийлөгч уулзахаараа баахан том юм ярина. Их Хурлын дарга нь очихоороо баахан том юм ярина. Парламентын бүлгэм очихоороо баахан том юм ярина. Тэгээд 20, 30 жилийн хугацаанд овоорчихсон байгаа цаас нь бараг ийм өндөр байгаа шүү дээ гишүүд ээ. Нэгийг нь ч шийддэггүй.

Тэгээд Монгол руу орж ирэхээрээ Монголын парламент руугаа чихээд, ингээд нэг нэгнээ хардаж сэрдээд, тэгээд тухайн улсын хувьд бол ямар ч нэр хүнд байхгүй. Одоо төмөр замын хөгжлийг яах юм. Коридорыг яах юм. Нөгөө Владивосток руу явж байгаа транзитаа яах юм. Эгийн голоо яах юм. Байхгүй. Тэгээд засаг солигдсон нэртэй дараагийн хүмүүс нь мартчихдаг. Үгүй ээ, ингээд хөрштэйгөө юмаа яриад ойлголцож чаддаггүй ард түмэнтэй дэлхий нийт ярих уу. Ийм зүйлийг л энэ парламентын гишүүд минь бодооч. Япон жишээлбэл, Монголтой юу ч ярихаа больсон. Японы Аж үйлдвэрийн яам дэргэдээ нэг жижигхэн Монголын хэлтэс шиг юмтай байсан. Одоо татаад буулгачихсан. Байхгүй. Ярьдаг газар байхаа больсон.

Солонгост яваад очихоор Монголыг ярьдаг юм байхгүй. Нэг үгээр хэлбэл 2 хөрштэйгөө учраа олж чадахгүй хүнтэй хүн ярихгүй байхгүй юу. Яагаад гэвэл тэр чинь тосгоны соёлтой улсууд учраас тосгоноосоо хөөгдсөн хүнийг хүн биш гэж үзээд байдаг байхгүй юу. Тэгэхээр Монгол бол энэ бүс нутагтайгаа нэг хүн шиг харьцаатай, өөрийн байр сууриа их тодорхой илэрхийлдэг, байр суурин дээрээсээ хөдөлдөггүй, эрх ашгаа эрэмбэлж чаддаг, яриа хөөрөөндөө яг таг байдаг гэдэг зүйлийг яг энэ хэлэлцээр харуулж байгаа шүү. Ийм дахиад 4, 5 том асуудал байгаа. Зүгээр хардалт сэрдэлтээс болоод л хойшоо тавьдаг. Хувийн компаниудын эрх ашгаас болоод л хойшоо тавьдаг.

Тийм учраас би зүгээр энэ хуулийн байнгын хорооны дарга Аюулгүй байдлын байнгын хорооны дарга хоёртоо л хэлж байгаа юм. Ер нь иймэрхүү популизмд орохгүйн тулд бид ер нь ямар түвшинд юмаа ярьдаг байх вэ гэдгийгээ та хэд минь нэг гаргаж өгөөрэй. Тэгээд шинэ Засгийн газар бүрдэхээр та нар Ардын намын гишүүд бас Ерөнхий сайдтайгаа яриарай. 5, 6 сараас бүтэц ярина гээд Ерөнхий сайд чинь дуугарчих шиг болно лээ. Тэр үедээ энэ ямар асуудлыг хаанаа шийддэг байх вэ гэдгийгээ их нарийн ярихгүй бол ний нуугүй хэлэхэд гадаад худалдаан дээр энд бид нар Аж үйлдвэрийн сайдыг барьж идээд байгаа байхгүй юу. Тэр чинь ерөөсөө л Гадаад хэргийн сайдын ажил шүү дээ. Дизель түлш, бензин орж ирж байна, орж ирэхгүй байна. Харилцаа ямар байна. Тэрнээс л шалтгаална. Худалдааны асуудал, зам тээврийн асуудал байгаа. Хамгийн гол дизель түлшний асуудал чинь ерөөсөө тээвэр байхгүй юу даа. Улаан-Үүдээс наашаагаа орж ирж байгаа тээврийн чинь Орос дахь дэд бүтэц хэр байна вэ. Ийм л асуудал байгаа шүү дээ. Яг байгаль далайг тойрсон тэр дэд бүтцийг оросууд маань шинэчилж өгөх юм уу.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Анар гишүүн үг хэлье.

Ч.Анар: Энэ гэрээний хэлэлцээрийг бол дэмжиж байгаа. Одоо гадаад нөхцөл байдал үнэхээр хүнд байна шүү дээ. Тэгэхээр Оросын Холбооны Улс өөрөө түлш, эрч эрчим хүч экспортлохоо хориглосон. Гэхдээ өмнөх Засгийн газрын байгуулсан хэлэлцээрийн хүчинд өнөөдөр бас тэр хоригт ороогүй явж байгаа гэж ойлгож байгаа. Хамгийн гол нь одоо энэ олон улсын хэлэлцээрүүд дээр бид нарын зүгээс хараад байгаа юм нь яг Цогтбаатар дарга үнэнийг хэлээд байгаа байхгүй юу. Энэ арилжааны хэлэлцээр. Тэнд 2 улсын харилцаагаа муутгахгүйн тулд сайн, муу байж болох, үүсэж болзошгүй бүх эрсдэлээ тооцож, гэрээнүүдээ тодорхой томъёолж оруулж ирдэг л баймаар байгаа байхгүй юу. Маш олон гэрээнүүд ингээд ийм бөөрөнхий, тодорхойгүй орж ирээд байгаа. Энэ нь эргээд ямар нэгэн байдлаар геополитикийн болон дотоодын улс төрийн нөхцөл байдлаас маргаан үүсэх юм бол өөр өөрийн өнцгөөрөө тайлбарлаад, 2 улсын харилцаанд эрсдэл үүсэх эрсдэлтэй.

Эдийн засгийн хувьд ч гэсэн маргаан үүсэхээр эрсдэлтэй байгаад байгаа юм. Тийм учраас өнөөдөр бол энэ гэрээг бид нар бас ажлын хэсэг мэдээж нэлээн олон юмыг тодорхой болгосон байна. Гэхдээ цаашдаа бас ингээд яамдууд болон Гадаад хэргийн яам анхаараад, эдийн засгийн, арилжааны хэлэлцээр хийхдээ гэрээний зүйл, заалт нөхцөлүүдийг илүү маш тодорхой болгож л оруулж ирдэг болохгүй бол үг үсэг дээрээсээ өгсүүлээд л асуудал үүсээд, тэр нь улс төржилт болоод байх эрсдэлүүд байна. Тэгээд гэрээг бол дэмжиж явуулна гэдгээ илэрхийлье. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Жадамбын Энхбаяр гишүүн үг хэлнэ.

Ж.Энхбаяр: 2024 онд Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч Путин Монгол Улсад албан ёсны айлчлал хийсэн. Тэрийг их олон янзаар дүгнэж байсан. Тэр

айлчлалын их том үр дүн бол Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийг байгуулж чадсан. Тэр хүрээнд дагалдаад энэ агаарын хөлгийн түлшний хангамж, нийлүүлэлтийг тогтвортой байдлаар хангах асуудал орж ирж байгаа.

Мэдээлэл өгөх маягаар Оросын Холбооны Улсаас бид нар ТС1 маркийн түлш авдаг. БНХАУ-ынх бол ЖЕТ А маркийн түлш. Одоо манай байгаа Чингис хаан нисэх буудал маань ТС1 түлшийг сумлах ийм системтэй. ЖЕТ А-н тэр систем байхгүй гэдгийг их сайн ойлгоно.

2 дугаарт БНХАУ-аас импортлоход вагон сэлгэн ачихтай холбоотой агаарын хөлгийн түлшийг хадгалах сав, дэд бүтэц Монгол Улсад байхгүй. Замын-Үүдийн боомтоор байхгүй. Тэгэхээр Оросын Холбооны Улсаас нийлүүлэлт 100 хувь хийж байгаа. Тэгэхээр бидэнд бол тогтвортой ба нийлүүлэлт онцгой чухал. Ялангуяа ялангуяа агаарын тээвэр сүүлийн жилүүдэд эрс өсөж байна. 2025 онд бид нар 2,4 сая жуулчин агаарын зорчигч авсан. Энэ тоо цаашаа улам өсгөхөөр байна. Зөвхөн Ойрх Дорнод гэхэд л бүс нутгийн чиглэж байсан 30 сая жуулчны хөдөлгөөн, бусад бүс рүү чиглэх бололцоо үүсэж байгаа. Тэгэхээр бид агаарын дэд бүтцээ энэ шатахууныхаа тогтвортой байдлыг хангах нь онцгой чухал юм байгаа юм. Тэгээд цаг нэлээн алдсан. Энэ гэрээ хийхгүй жил гаруй болчихлоо. Үр дүнд нь бид үнэ дээр нэлээн асуудлууд нэлээн үүсгэчихсэн. ТС1-ээс их үнэтэй болсон. Монголын МИАТ компаниудын алдагдал шатахууны үнэтэй холбоотойгоор нэлээн бид нар хохирол амссан. Тэгэхээр энэ тогтвортой байдлаа хийгээд гэрээгээ хийгээд ингээд тогтворжуулаад явах нь зүйтэй. 1 жишээ хэлэхэд бид нар АИ 92 дээр хийсэн гэрээ маань сүүлийн 5 жил тогтвортой байдлаа хангаж чадаж байгаа шүү дээ. 1 үнээр хийчихсэн. Тэгэхээрээ урт хугацаанд тогтвортой үнийн нийлүүлэлтээ хийх нь бид нарын гол эрх ашиг юм. Тэгэхээр энэ гэрээгээ яаралтай хийгээд, энэ тогтвортой байдлаа хангах нь чухал байна.

Хэлэлцээр маань 20 жил байсныг өөрчлөөд, 15 жил болсон. Энэ гэрээ 15 жил мөрдөнө. Энэ хугацаанд бид нар 2 дахь эх үүсвэрээ нөгөө ЖЕТ А маркийг оруулах, дэд бүтцийг бий болгох, манай Чингис хаан нисэх буудал маань 8 гарцтай нисэх буудал маань ачаалал нь 100 хувьдаа хүрсэн, давчихсан. Одоо 11 гарцтай. Шинэ буудлын асуудлыг Япон улстай яриад, гэрээ хэлэлцээртээ орчихсон байна. Энэ үедээ бид нар дагасан А ЖЕТ буюу олон эх үүсвэрийн сумлагаа хийх бололцоог бүрдүүлэх, Замын-Үүдийн тэр боомт дээрх импортын дамжин, сэлгэн ачих тэр чадавхыг бүрдүүлэх гээд бид өөрсдөө хийх ажлууд их байгаа.

Өнөөдөр юунаас илүү тогтвортой нийлүүлэлт, тогтмол үнэ байх нь бид нар онцгой чухал байна шүү гэж .../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Дашдондогийн Ганбат гишүүн үг хэлье.

Д.Ганбат: Яах вэ, ер нь бид нар тал талаасаа Улсын Их Хурал чуулган дээр энэ Байнгын хороод дээр энэ гэрээ хэлэлцээр, энэ асуудлуудыг ярьдаг нь зөв юм. Зөв байгаа байхгүй юу. Яагаад вэ гэхээр энэ ард түмэн чинь хараад, сонсоод, энэ асуудал чинь юундаа байдаг юм. Хэнээс, юунаас нь болсон юм. Дараа нь яах ёстой юм гэдгийг ярьж байгаа хүмүүс ч гэсэн бодож байх ёстой байхгүй юу. Хариуцлагатай ярих ёстой. Өдий хүртэл маш харалган бодлого явуулж байсны үр дүнд гарцаагүй нэг буу тулгуулж байгаа юм шиг ийм гэрээ хэлэлцээрүүдийг хийж байгаа байхгүй юу. Тухайлбал, тэр Харбины гэрээ байна. Одоо энэ шинэ намын дарга, Улсын Их Хурлын дарга, одоо Ерөнхий сайд болж байгаа Учрал дарга манай Архангай аймагт

очиход иргэд хэлж байна лээ шүү дээ. Тэр гэрээ хэлэлцээрийг нь та нар нэг нээлттэй болгоод өгчхөөч ээ. Тэр Баярмаа, Ганбат гишүүн 2-ын яриад байгаа тэр сонсголыг нь хийчхээч ээ гээд байгаа байхгүй юу. Ингэж хийж, ярих болохоор чинь зөв байхгүй юу. Яагаад гэвэл олон нийт ингээд харж байгаа. Дэлхий нийт ч гэсэн харж байгаа байхгүй юу. Энэ олон элчин сайдууд ч гэсэн. Энэ жижигхэн улс 3 сая 500 мянган хүнтэй. Энд бол нэг их ашиг орлого, энээ тэрээ юмыг нь 2 хөрш бол барьдаггүй. Бид нарыг хөгжөөсэй гэж боддог. Манай энэ харалган дарга нараас л болж байгаа байхгүй юу. Зориуд гэрээ хэлэлцээрийг буруу хийдэг, алдагдалтай хийдэг, ашиггүй хийдэг. Дараа нь хэцүү байдалд оруулдаг ийм л юм байлаа шүү дээ. Одоо хар л даа. Бид нар тэр Владивосток боомт хүртэл төмөр замтай болчихсон. Тэндээс нефтээ татаад, бензинээ татаад ийм болчихно л гээд байсан. Хаана байгаа юм. Одоо өнөөдрийг хүртэл бензин шатахуунаа хадгалдаг сав нь ч байхгүй. Тэгээд 1 мэргэн цэцэн хүмүүс энэ дээр гарцаагүй ийм болчихлоо. Ийм сайхан гэрээ хийж байна гээд байгаа байхгүй юу.

Энэ хар л даа ОХУ, Беларусь улс 2 бараг ойролцоо, адилхан. 1 чиг бодлоготой байдаг ийм улсууд. Энэ бол хоёулаа л хоригт ордог ийм улсууд. Тэгээд тэнд шилжүүлчихлээ энэ тэр гээд. Аль болохоор бид нар 2, 3 эх үүсвэрээс авах ёстой. Өмнөд хөршөөсөө авах ёстой. ОХУ маань дайнтай байна. Тэгээд ингээд гэрээ хэлэлцээр бид нар хийчихлээ. Энэ ажлаа болгочихлоо гээд иймэрхүү юм яриад сууж болохгүй ээ нөхөд минь.

Одоо бид нар хариуцлага ярьж байх ёстой байхгүй юу. Яагаад сав суулгаа едий болтол бэлдээгүй юм. Яагаад нефтийн үйлдвэр ийм их мөнгө орчхоод одоо болтол оруулаагүй юм. Энэ бүгдийг бид нар нээлттэй ярьж, хэлэлцэж байх ёстой. Энэ хүмүүстэйгээ бид нар хариуцлага тооцож байх ёстой байхгүй юу. Ард түмэн мэдээж хэрэг сонгуулиар хариуцлага тооцно. Одоо энэ бензин тосоор тасалдуулж байсан, эрчим хүчээр тасалдуулж байсан энэ бүх юмыг чинь бол тэр ой санамждаа хийчихсэн байгаа шүү дээ. Ийм юм мартагддаггүй ард түмэнд. Тэгээд одоо жижиг намуудад үүрүүлээд л, нэр төдий. Тэгээд өнгөрөөнө гэж байна уу. Тэр боловсролын салбарыг, тэр эрчим хүчний салбарыг. Ийм байж болохгүй юм байгаа юм. Тэгээд энэ юмыг сайхан дэлгэрэнгүй ярьж ингэж хийж байх ёстой. Энэ гэрээ хэлэлцээрээ ахиж харах хэрэгтэй. Жишээлбэл, одоо манайхан тэр Ормуз-ын хоолой гээд ганц нэг нь ярьж л байна. Тэр Перс, Иран, АНУ, Израйлын дайн гээд. Мэдээж хэрэг тэнд бол үүний эх үүсвэр нь бүх дэлхийд, бүх улс орнуудад нөлөөлж байгаа шүү дээ. Бордоо гээд л. Түүнээс гадна аягүй бол удахгүй тэр цэвэр усны нөөцөд нь цохилт өгнө гэж байгаа шүү дээ. Тэгвэл юу болох юм бүү мэд. Ийм үе шаттай юмнууд ингээд нэг нь нөгөөдөө нөлөөлдөг домино шиг юм явж байгаа байхгүй юу. Тэгэхгүй/минут дуусав/

Г.Тэмүүлэн: Очирбат гишүүн үг хэлье.

Г.Очирбат: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Энэ асуудал бол урьд нь бас орж ирж байсан. Тэгээд Их Хурлын гишүүд, ялангуяа мэргэжлийн Байнгын хорооны гишүүд олон санал санаачилгуудыг бас дэвшүүлсэн. Энийг бас манай яамныхан авч залруулж ажилласан байна. Баяр хүргэе. Дамдинням сайдтай яг энэ асуудалтай холбоотой бас урьд нь 2, 3 хурал дээр таарч, мэдээллүүд авсан. Бас нэлээн зүтгэсэн юм байна лээ. Дэлхийн нөхцөл байдал ингэж хүндэрнэ гэдгийг бол ер нь хэн ч таахгүй шүү дээ. Энэ чинь давагдашгүй хүчин зүйлс тулгарч байна.

Тэгэхээр энэ дээр бол энэ хэлэлцээрийг дэмжээд явахаас өөр аргагүй. Яг өнөөдрийн нөхцөл байдал. Магадгүй Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Дамдинням

үлдэж магадгүй. 1 бол дараагийн сайд гарч ирэх байх. Дараагийн сайдад бас үг хэлмээр байгаа юм. Аж үйлдвэр гэдэг үг чинь урд нь байгаа шүү. Цаашдаа ер нь бид нар ийм шахаанд орсон нөхцөл байдалд орж шийдвэр гаргадаг. Энийгээ Монгол Улс бол бодлогодоо бол зогсоох хэрэгтэй. Дэлхийн өнөөдөр эрчим хүчний асуудал дээр бүх улс эх оронд тулгарч байна. Дээрээс нь ялангуяа нефттэй холбоотой дэлхийд хэдхэн оронд байдаг энэ нөөцөөс хэдүүлээ яаж салах вэ гэдэг дээр толгойгоо ажиллуулж байгаа юм. Энэ бол сэргээгдэх эрчим хүч. Би Дамдинням сайдад бас хэлээд байгаа. Сэргээгдэх эрчим хүч. Бид нар Төв Азийн цээжинд байгаа. Цаашдаа Монгол Улс бол мэдээж 2 хөрштэйгөө энэ стратегийн хамтын түншлэлээ хэрэгжүүлээд явна. Найрсаг харилцаатай явна. Энэ бол ойлгомжтой.

Тэгэхдээ Монгол Улс өөрсдөө бодлогоор, ялангуяа энэ эрчим хүчний салбар дээрээс нь энэ түлшний салбар дээр өөрсдөө үйлдвэрлэлээ хийх ёстой шүү. Нефть боловсруулах үйлдвэрийн өнөөдрийн нөхцөл байдал бол үнэхээр бас хүнд байгаа. Та хэд энийг бас нээлттэй хэлээрэй. Тэгээд ковид гарсан гэж 1 шалтгаан ярьдаг. Хөрөнгө оруулалт зогсож байна гэж 1 шалтгаан ярьж, мөнгө нэхдэг. Очоод хийсэн ажил, бодитой юмнуудыг нь үзэхээр мэдээж тодорхой хэмжээний ажил хийгдсэн байгаа. Тэгэхдээ цаг хугацаандаа шахаж төлөвлөгөөтэй, тэр үнэхээр хийж чадахгүй бол халдаг, сольдог, хариуцлага тооцдог юм явахгүй байгаа шүү.

Тэгэхээр энэ дээр манай энэ мэргэжлийн яамдынхан бас та хэд маань шахаж ажиллах ёстой. Энийгээ одоо яг ажил болгож хийгээрэй. Тэгээд л ингээд сайд солигдонгуут яадаг юм, 1 сайд ирэнгүүт толгойг нь илж, анхаарлыг нь сарниулж байгаад энэ явчихна даа гэдэг байдлаар төрийн албан хаагч нар маань хандаж болохгүй шүү. Бүх яамнууд дээр ерөөсөө яг үнэн. Одоо бараг энэ сайд нарыг чинь зүгээр ийм шувууд ирээд буцдаг гэдэг ийм яриа гарчихсан.

Тэгэхээр манай энэ Төрийн нарийн бичгийн дарга нар, ахлах мэргэжилтнүүд, мэргэжлийн албан хаагч нар маань нэг юм бодоорой та хэд. Төрийн хар хайрцаг цаашаа үргэлжлэх ёстой. Ялангуяа эрчим хүч, түлшний салбар дээр. Тэгээд аж үйлдвэр гэдэг нэрийг урдаа авчихсан байгаа шүү. Бид нар дахиад ингээд 2, 3 жилийн дараа, 4 жилийн дараа, 5 жилийн дараа ийм асуудал яриад сууж баймааргүй байгаад байгаа юм. Ядаж бид нар дотоодоосоо эрчим хүчээр явдаг, магадгүй энэ аж ахуйн нэгжүүд дээр явдаг том техник хэрэгслүүд, иргэд маань унадаг машинууд бол дэлхий өөрчлөгдөж байгаа, өөрчлөгдөөд л явна. Тэгэхээр энэ нөөцөө анхаарч, энэ нөөц дээрээ тулгуурласан энэ үйлдвэрлэлийн салбаруудаа дэмжиж яваарай гэж хүсэх гэсэн юм.

Хамгийн сүүлд нь ингээд нефть шатахууны үнэ өснө. Тэгэхээр манай аж ахуйн нэгжүүд өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг шууд нэмдэг шүү. Энийг та хэд маань бас жоохон бодлоготой, бид ч гэсэн бас хэлж ярих ёстой. Хамгийн энгийн 1 жишээ би та хэдэд хэлье. Тэтгэврийг 10 хувиар нэмэхэд ямар ч хамааралгүй би нэрийг нь хэлээд яах вэ, аж ахуйн нэгжүүдийнхээ. Зарим аж ахуйн нэгжүүд өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийхээ үнийг 10 хувиар нэмж байсан юм шүү. Тэр тэтгэвэр 10 хувиар нэмэгдэхэд, тэр үйлдвэрлэж байгаа бараа бүтээгдэхүүний өртөгт нөлөөлөхгүй. Эрчим хүчний энэ түлшний салбар яалт ч үгүй нөлөөлнө. Тэгэхдээ аж ахуйн нэгж, иргэд энэ төрийн яам, Тамгын газрууд, Их Хурлын гишүүд ч гэсэн анхааралтай байж, иргэдийнхээ өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт дээр яг бодитой бас судалгаатайгаар асуудлуудыг ярьж хэлж ойлгуулах нь чухал байгаа шүү. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Гишүүд үг хэлж дууслаа. Ажлын хэсгийнхэн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамныхан, Гадаад харилцааны яамны бас холбогдох газрын дарга нар бас хүрэлцэн ирсэн байгаа. Та нар бас гишүүдийн хэлсэн асуудлууд дээр бас анхаарч ажиллаарай. Одоо бол зөвхөн зөвшилцөх асуудлаар орж ирж байгаа, соёрхон батлуулахаар бол Улсын Их Хуралд оруулж ирнэ. Тэгэхээр эргээд юу гэдэг юм. Протоколд гарын үсэг зурахдаа сайжруулах талаар гишүүдийн хэлсэн саналуудыг тусгах чиглэлээр, тодорхой болгох чиглэлээр бол анхаарч ажиллах, ярилцах шаардлага бол байна гэдгийг удаа дараа гишүүд бас хэлж байна. Соёрхон батлахдаа бид нар бас энэ асуудлуудыг бол илүү тодорхой болгож, анхаарал хандуулж ажиллах шаардлага бол байна гэж харж байгаа юм.

Зарчмын хувьд бол бид нар энэ Засгийн газар хоорондын хэлэлцээрийг бол дэмжих ёстой. Зарчмын хувьд, дээрээс нь гадаад яам ер нь томоороо энэ саяын Гантөмөр гишүүний хэлж байгаа олон улсын гэрээ хэлэлцээртэй холбоотой, хэрэгжилттэй холбоотой эдгээр юу гэдэг юм, гэрээ хэлэлцээрүүдийн хэрэгжилттэй холбоотой асуудлууд дээр бас онцгойлж анхаарах шаардлага байна. Хөрш газрын дарга Жанабазар дарга ирсэн байна. Газрын захирал, Гэрээ эрх зүйн газрын захирал Соёлмаа ирсэн байна. Бид нар өнгөрсөн 7 хоногт эргээд Гадаад харилцааны яаманд хүсэлт тавиад, эргээд Гадаад харилцааны яамны тайлан мэдээллүүдийг нь сонсьё гэдэг асуудлыг тавьсан. Гадаад харилцааны сайдын хүсэлтийн дагуу эргээд одоо 7 хоног энэ асуудлыг хойшлуулсан. Бид нар өчигдөр бас Хууль зүйн байнгын хороо болоод Аюулгүй байдлын байнгын хороо 2 хамтарсан хурал хийж, олон улсын гэрээ хэлэлцээр болоод, тэдгээрийн биелэлттэй холбоотой асуудлыг авч хэлэлцье. Тайланг нь сонсьё гэдэг асуудлыг бас тавьсан байсан. Өчигдөр яг хурал эхлэхтэй холбогдуулаад 2 Байнгын хороонд Гадаад харилцааны яамнаас хүсэлт явуулаад, энэ асуудлууд дээр бид нар ажлын хэсэг гарч ажиллаж байгаа. Мэдээллээ шинэчлэх шаардлагатай байгаа тул 7 хоногоор хойшлуулж өгөөч гэсэн хүсэлтийг өгсөн байгаа.

Тэгэхээр Гадаад харилцааны яам дараа 7 хоногт бол яг бүтэн жилийнхээ тайлантай холбоотой мэдээллийг манай Байнгын хороонд бас бүрэн дүүрэн тавиад, гишүүдэд энэ мэдээллүүдээ өгөөд, тулгамдаж байгаа асуудлуудаа яриад явах шаардлагатай байна.

2 Байнгын хорооны хурал дээр олон улсын гэрээний биелэлттэй холбоотой хэрэглэгчдийнхээ тайланг бас дэлгэрэнгүй танилцуулах хэрэгтэй байгаа. Яагаад вэ гэхээр үндсэндээ бид нар ийм геополитикийн хүнд нөхцөл дээр гадаад бодлого дээр алдаа гаргах эрх байхгүй байгаад байгаа юм. Алдаа гаргах эрх байхгүй. Бид бүхэн илүү юу гэдэг юм, бодлоготой байх, илүү тодорхой байх, илүү ажил хэрэгч, хурдан шуурхай байх ийм зайлшгүй шаардлага байна. Тэгээд энэ ч үүднээс бид нар бас цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулж, эргээд энэ 2 асуудлыг бол тавьж байгаа шүү. Цаашдаа хагас жил тутам болон жил болгон энэ олон улсын гэрээний хэрэгжилт, биелэлтийн тайлан, мөн яамны жилийн, хагас жилийн тайлангуудыг бол байнга сонсож байх болно.

Тэгээд энэ асуудал бол дараа 7 хоногт байна. Та бүхэн хариуцлагатай хандаж, эдгээр асуудлууд дээр бас мэдээллүүдийг, тайлангуудаа гишүүддээ дэлгэрэнгүй тавиарай гэдгийг бас онцгойлон хэлэх байна.

Ингээд санал хураалтад бэлтгэе. Бэлэн болсон байна. Санал хураалтыг явуулж эхэлье.

“Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах тухай протоколын төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн томьёолоор санал хураалт явуулах юм байна. Санал хураалт. Төхөөрөмж дээр 63,2 хувиар буюу 19 гишүүн оролцсоноос 12 гишүүн дэмжсэн байна. Гантөмөр гишүүний төхөөрөмж ажиллаагүй гээд дэмжсэнээр орж байна. Нийт 19-13 гишүүн дэмжсэн байна.

Ажлын хэсгийнхэнд амжилт хүсье. Яриа хэлэлцээгээ бас цаашаа сайтар явуулаарай.

15.44 цаг.

Бусад үлдсэн 3 асуудал байгаа. Эдгээр асуудлууд дээр бол Төрийн нууцын тухай хууль шинэчилсэн найруулга нь байсан. Мөн Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөл байсан. 3 дахь нь Гадаад харилцааны яамны үйл ажиллагааны талаарх сайдын мэдээллийг сонсохоор байсан. Эдгээр асуудлуудыг Засгийн газраас хүсэлт тавьсны дагуу 7 хоногоор хойшлуулсан байна. Ингээд эдгээр асуудлуудыг хойшлууллаа.

Хэлэлцэх асуудлаа хэлэлцэж дууслаа. Өнөөдрийн хуралд идэвхтэй оролцсон Байнгын хорооны гишүүддээ баярлалаа. Хурал хаасныг мэдэгдье.

15.44 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ